



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ТӨААТУГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/30/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер Г.Гүнжидмаа  
Утас: 261628 Цахим хаяг: [gunjiddmaag@audit.gov.mn](mailto:gunjiddmaag@audit.gov.mn)  
Аудитор С.Алтанхуяг  
Утас: 261740 Цахим хаяг: [altankhuyags@audit.gov.mn](mailto:altankhuyags@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк ОМ Аудит ХХК  
Захирал: Б.Жаргалсайхан  
Цахим хаяг: [peakomaudit@gmail.com](mailto:peakomaudit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	11
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	14
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	14
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	14
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
8. Аудитын илрүүлэлт .....	17
8.1 Залруулсан алдаа .....	17
8.3 Албан шаардлага .....	17
8.4 Зөвлөмж .....	18
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙРУУДЫН  
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР  
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Ө.ЛУВСАНРЕНЧИН ТАНАА

2022.03.15 № 07/543  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон зүйл

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь тайлант онд Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын харьяанд шилжсэн ба байгууллагын дүрмийг шинэчлэн батлаагүй байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан бөгөөд аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

## **Бусад асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан ба цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй болно.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
			/төгрөгөөр/
1	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	801,527,849.83	1,551,012,945.88
1.1.2	Дансны авлага	217,140,294.00	9,747,786.80
1.1.3	Татвар. НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	484,709,090.99	514,314,358.39
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	0.00	88,813,617.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,503,377,234.82</b>	<b>2,163,888,708.07</b>
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,683,578,549.23	7,884,055,350.16
1.2.2	Биет бус хөрөнгө	714,555,114.66	711,549,293.82
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө орлуулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>9,398,133,663.89</b>	<b>8,595,604,643.98</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,901,510,898.71</b>	<b>10,759,493,352.05</b>
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1	<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.1.1	Дансны өглөг	190,990,883.00	360,000.00
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	0.00	0.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	60,179,074.91	200,983,774.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	36,985,212.00	38,335,887.15
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө ( борлуулах бүлэг хөрөнгө )-нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>288,155,169.91</b>	<b>239,679,661.15</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын  
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>288,155,169.91</b>	<b>239,679,661.15</b>
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	7,955,637,235.90	7,955,637,235.90
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	757,597,449.00	757,597,449.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,248,329,224.49	3,248,329,224.49
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,088,554,901.00	1,074,875,175.28
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,436,763,081.59)	(2,516,625,393.77)
2.3.9.1	Өмнөх үеийн үр дүн	(2,190,153,555.24)	(2,429,766,349.59)
2.3.9.2	Тайлант үеийн үр дүн	(246,609,526.35)	(86,859,044.18)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>10,613,355,728.80</b>	<b>10,519,813,690.90</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>10,901,510,898.71</b>	<b>10,759,493,352.05</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>5,885,539,957.67</b>	<b>6,212,298,943.22</b>
2	Борлуулалтын өртөг	5,770,453,732.00	6,049,254,261.88
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>115,086,225.67</b>	<b>163,044,681.34</b>
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүгийн орлого	28,784,931.33	16,893,412.36
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	9,963,750.00	1,483,404.00
9	Борлуулалт. маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	397,565,940.20	266,591,200.64
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	2,878,493.15	1,689,341.24
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(246,609,526.35)</b>	<b>(86,859,044.18)</b>
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(246,609,526.35)</b>	<b>(86,859,044.18)</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(246,609,526.35)</b>	<b>(86,859,044.18)</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>246,609,526.35)</b>	<b>(86,859,044.18)</b>
25	<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)</b>		



### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>7,955,637,235.90</b>	<b>757,597,449.00</b>	<b>3,248,329,224.49</b>	<b>685,905,540.00</b>	<b>(2,174,359,555.24)</b>	<b>10,473,109,894.15</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө. алдааны залруулга					(15,794,000.00)	(15,794,000.00)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>7,955,637,235.90</b>	<b>757,597,449.00</b>	<b>3,248,329,224.49</b>	<b>685,905,540.00</b>	<b>(2,190,153,555.24)</b>	<b>10,457,315,894.15</b>
Өмчид гаргасан өөрчлөлт				402,649,361.00		402,649,361.00
Зарласан ногдол ашиг						
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )					(246,609,526.35)	(246,609,526.35)
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>7,955,637,235.90</b>	<b>757,597,449.00</b>	<b>3,248,329,224.49</b>	<b>1,088,554,901.00</b>	<b>(2,436,763,081.59)</b>	<b>10,613,355,728.80</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө. алдааны залруулга					6,996,732.00	6,996,732.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>7,955,637,235.90</b>	<b>757,597,449.00</b>	<b>3,248,329,224.49</b>	<b>1,088,554,901.00</b>	<b>(2,436,763,081.59)</b>	<b>10,620,352,460.80</b>
Өмчид гаргасан өөрчлөлт				(13,679,725.72)		(13,679,725.72)
Зарласан ногдол ашиг						
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )					(86,859,044.18)	(86,859,044.18)
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>7,955,637,235.90</b>	<b>757,597,449.00</b>	<b>3,248,329,224.49</b>	<b>1,074,875,175.28</b>	<b>(2,516,625,393.77)</b>	<b>10,519,813,690.90</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,480,821,450.34	6,809,863,630.81
1.1.1	Бараа борлуулсан. үйлчилгээ үзүүлсэний орлого	6,070,524,148.62	6,713,779,675.81
1.1.2	Эрхийн шимтгэл. хураамж. төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас. санхүүжилтийн орлого	406,664,481.00	94,963,955.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,632,820.72	1,120,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,467,334,809.71	6,077,271,947.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,981,531,283.00	1,962,742,694.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	582,600,568.11	605,526,355.92
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,671,558,346.29	3,295,166,968.34
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш. шатахуун. тээврийн хөлс. сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,033,088.00	643,688.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	161,505,645.11	158,506,958.24
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	150,000.00
1.2.9	Шагнал урамшууллын зардал	1,469,849.00	300,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	63,636,030.20	54,235,282.62
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,486,640.63	732,591,683.69
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	28,784,931.33	16,893,412.36
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл. мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	28,784,931.33	16,893,412.36
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	28,784,931.33	16,893,412.36
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын  
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

3.1.1	Зээл авсан. өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл. өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,271,571.96	749,485,096.05
5	Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	759,256,277.87	801,527,849.83
6	Мөнгө. түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	801,527,849.83	1,551,012,945.88

**2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

/төгрөгөөр/

№	Эдийн засгийн зорилтот үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>5,924,288.64</b>	<b>5,924,288.64</b>	<b>6,230,675.76</b>	<b>(306,387.12)</b>	<b>105.17</b>
	Төсөвт байгууллагад үзүүлсэн ажил үйлчилгээний орлого	5,707,260.46	5,724,288.64	6,081,967.43	(357,678.79)	106.25
	Өмчийн орлого	172,492.86	200,000.00	74,495.50	125,504.50	37.25
	Бусад орлого	15,750.39		57,319.42	(57,319.42)	
	Хүүгийн орлого	28,784.93		16,893.41	(16,893.41)	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>	<b>6,170,898.16</b>	<b>6,388,528.84</b>	<b>6,317,534.80</b>	<b>70,994.04</b>	<b>98.89</b>
<b>21</b>	<b>БАРАА. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,059,623.81</b>	<b>6,327,528.84</b>	<b>6,209,991.53</b>	<b>117,537.31</b>	<b>98.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлсний зардал</b>	<b>2,727,116.03</b>	<b>2,894,250.00</b>	<b>2,727,136.70</b>	<b>167,113.30</b>	<b>94.23</b>
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,418,600.48	2,550,000.00	2,406,552.36	143,447.64	94.37
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	308,515.55	344,250.00	320,584.33	23,665.67	93.13
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,299,309.41</b>	<b>1,317,884.39</b>	<b>1,325,415.04</b>	<b>(7,530.65)</b>	<b>100.57</b>
	Гэрэл. цахилгаан	826,558.01	837,653.46	772,511.83	65,141.63	92.22
	Түлш. халаалт	358,061.21	360,905.37	428,408.86	(67,503.49)	118.70
	Цэвэр. бохир ус	114,690.19	119,325.56	124,494.35	(5,168.79)	104.33
<b>2104</b>	<b>Хангамж. бараа материалын зардал</b>	<b>429,142.34</b>	<b>428,534.45</b>	<b>422,367.99</b>	<b>6,166.46</b>	<b>98.56</b>
	Бичиг хэрэг	8,989.17	8,547.45	8,785.98	(238.53)	102.79
	Тээвэр. шатахуун	15,602.14	10,000.00	10,267.59	(267.59)	102.68
	Шуудан. холбоо. интернэтийн төлбөр	6,799.02	6,799.00	6,284.71	514.30	92.44
	Ном. хэвлэл	513.70	520.00	226.03	293.97	43.47
	Хог хаягдал зайлуулах	46,835.00	52,668.00	44,460.00	8,208.00	84.42
	Хортон мэрэгчдийн устгал ариутгал	24,922.16	25,000.00	22,991.60	2,008.40	91.97
	Бага үнэтэй. түргэн элэгдэх. ахуйн эд зүйлс	325,481.16	325,000.00	329,352.09	(4,352.09)	101.34
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,458.79</b>	<b>9,900.00</b>	<b>14,749.08</b>	<b>(4,849.08)</b>	<b>148.98</b>
	Эм. бэлдмэл. эмнэлэгийн хэрэгсэл	846.39	900.00	1,956.95	(1,056.95)	217.44
	Нормын хувцас. зөөлөн эдлэл	8,612.39	9,000.00	12,792.14	(3,792.14)	142.13
<b>2106</b>	<b>Эд хогшил. урсгал засварын зардал</b>	<b>522,109.30</b>	<b>566,000.00</b>	<b>573,367.96</b>	<b>(7,367.96)</b>	<b>101.30</b>
	Багаж. техник. хэрэгсэл	28,563.07	15,000.00	12,371.91	2,628.09	82.48
	Тавилга					
	Урсгал засвар	493,546.23	551,000.00	560,996.05	(9,996.05)	101.81

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын  
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр. хураамж</b>	<b>168,892.13</b>	<b>190,960.00</b>	<b>198,307.88</b>	<b>(7,347.88)</b>	<b>103.8</b>
	Аудит. баталгаажуулалт. зэрэглэл тогтоох	5,200.00	5,200.00	5,780.00	(580.00)	111.15
	Даатгалын үйлчилгээ	826.18	450.00	415.54	34.46	92.34
	Тээврийн хэрэгслийн татвар	301.85	150.00	161.64	(11.64)	107.76
	Банк. санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	235.46	300.00	206.62	93.38	68.87
	Газрын төлбөр	4,607.84	4,500.00	5,726.28	(1,226.28)	127.25
	Мэдээлэл. технологийн үйлчилгээ	9,125.80	9,000.00	8,381.80	618.20	93.13
	Харуул хамгаалалтын зардал	148,595.00	171,360.00	177,636.00	(6,276.00)	103.66
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>903,595.81</b>	<b>920,000.0</b>	<b>948,646.89</b>	<b>(28,646.89)</b>	<b>103.11</b>
	Бараа. үйлчилгээний бусад зардал	45,079.70	45,000.00	48,535.04	(3,535.04)	107.86
	Элэгдлийн зардал	846,977.75	850,000.00	885,220.95	(35,220.95)	104.14
	Хичээл. үйлдвэрлэлийн дадлага хийх	11,538.36	25,000.00	14,890.90	10,109.10	59.56
<b>2132</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>111,274.35</b>	<b>61,000.00</b>	<b>107,543.26</b>	<b>(46,543.26)</b>	<b>176.30</b>
	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,565.56	46,000.00	21,362.38	24,637.62	46.44
	Нэг удаагийн буцалтгүй тусламж	60,075.63	10,000.00	85,880.88	(75,880.88)	858.81
	Шагнал урамшуулал	4,633.17	5,000.00	300.00	4,700.00	6.00
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>(246,609.52)</b>	<b>(464,240.20)</b>	<b>(86,859.04)</b>	<b>(377,381.16)</b>	<b>18.71</b>
<b>4</b>	<b>Авллага</b>	<b>217,140.29</b>	<b>217,140.29</b>	<b>9,747.79</b>	<b>207,392.51</b>	<b>4.49</b>
<b>5</b>	<b>Өглөг</b>	<b>288,155.17</b>	<b>288,155.17</b>	<b>239,319.66</b>	<b>48,835.51</b>	<b>83.05</b>

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримтын бүрдэлт, авлагын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 10-наас 2022 оны 3 дугаар сарын 10-ны хооронд Пийк ОМ Аудит ХХК-ийн ахлах аудитор А.Мөнхцэцэг, аудитор А.Батболд нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Наранчимэг, захирал Б.Жаргалсайхан нар хэрэгжүүлсэн.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 62 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Дотоод хяналт**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангын зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардал 6,170.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 61.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын зорилго нь Үйлчлүүлэгчдэд олон улсын стандартад нийцсэн нийтлэг үйлчилгээ үзүүлж, тэдгээрийн ажиллах, үйл ажиллагаагаа явуулах хэвийн, таатай орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Байгууллагын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг төрийн захиргааны төв байгууллагуудад үзүүлэх нийтлэг үйлчилгээг хариуцан ажиллах гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд төрийн өмчин аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 13-ны 11 дүгээр тогтоолоор Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын харьяанд шилжсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу зардлыг 71.0 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	801.5	1,551.0	749.5
Авлага	217.1	9.7	(207.4)
Урьдчилж төлсөг зардал / тооцоо/		88.8	88.8
Бараа материал	484.7	514.3	29.7
Үндсэн хөрөнгө	8,683.6	7,884.1	(799.5)
Биет бус хөрөнгө	714.6	711.5	(3.1)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>10,901.5</b>	<b>10,759.4</b>	<b>(142.1)</b>
Өр төлбөрийн дүн	288.2	239.6	(48.6)
Богино хугацаат өглөг	288.2	239.6	(48.6)
Эздийн өмч	10,613.3	10,519.8	(93.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>10,901.5</b>	<b>10,759.4</b>	<b>(142.1)</b>

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 943.4 сая төгрөг, хугацаатай хадгаламж 607.3 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 9.7 сая төгрөгийн авлага нь төлбөрт үйлчилгээний авлага байна.

Тайлант онд бараа материалын нөөцөд 33.5 сая төгрөг, урсгалын засварын ажлын төлбөрт 55.3 сая төгрөг, нийт 88.8 сая төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 514.3 сая төгрөг болж 29.6 сая төгрөгөөр өссөн нь цэвэрлэгээ, цайны нормын материалын нөөц бүрдүүлсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд дуусаагүй барилга, их засварын зардал 146.5 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулсан 37.8 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэн байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 203 тогтоолоор 60.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 1.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг, 2021 оны А-1/2109 дүгээр тогтоолоор нийт 51.8 сая төгрөгийн анхны өртөгтэй, 0.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг төсөвт байгууллагуудад балансаас балансд шилжүүлжээ.

Биет бус хөрөнгө 711.5 сая төгрөг болж 3.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлээс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 239,7 сая төгрөгийн өр төлбөрт ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого 201.0 сая төгрөг, түрээсийн барьцаа 38.3 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 0.4 сая төгрөг байна.

Тайлант онд цэвэр алдагдал 86.5 сая төгрөг болж, төлөвлөснөөс 377.4 сая төгрөгөөр дутуу нь төлбөрт үйлчилгээний орлого 306.4 сая төгрөгөөр нэмэгдэж, зардал 71.0 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалсан байна.



ТӨБЗГ-т 2021 оны 82.9 түрээсийн төлбөрийн 40 хувь болох 33.2 сая төгрөгийн түрээсийн орлого төвлөрүүлжээ.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ-ын захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 105 тоот албан бичгээр Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлагдсан байна.

Тайлант онд нийт орлогыг 5,924.3 сая төгрөгөөр, зардлыг 6,388.5 сая төгрөгөөр, 464.2 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 100.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 6,230.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,317.5 сая төгрөгийн зардал гарч 86.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Зардлыг төсөвлөснөөс нийт дүнгээрээ 71.3 сая төгрөгөө дутуу зарцуулсан нь цалин хөлсний зардал 167.1 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 6.2 сая төгрөгийг тус тус зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Тайлант онд цар тахлаас шалтгаалан эд хогшил, урсгал засварын зардал 7.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 28.6 сая төгрөг тус тус хэтэрсэн байна.

### **5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **5.1 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах мэдээллүүдээ 100 хувь бүрэн мэдээлсэн байна.

#### **5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 55.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 54.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгснөөс 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1		1				
Зөвлөмж	1	0.2	1	0.2			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>0.2</b>	<b>2</b>	<b>0.2</b>			

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын Сангийн яамтай байгуулсан ажил, нийтлэг үйлчилгээ үзүүлэх гэрээний үнийн дүн болон гэрээний гүйцэтгэлийн дүнгүүд зөрүүтэй, гэрээнд үнийн дүн тавьсан боловч төлбөр тооцоог гүйцэтгэлээр гэж тусгасан болон тайлант онд 2 ажилтан ээлжийн амралтаа биеэр эдлээгүй зэрэг нь дараагийн аудитаар анхаарах асуудлууд юм.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 113.6 сая төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 58.6 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 54.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 55.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 61.7 сая төгрөгийн материаллаг байдлын түвшинээс 6.7 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 58.6 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 7.0 сая төгрөг бичиг хэргийн материалд бүртгэлтэй байна.;
- Бараа материал олгосон 51.6 сая төгрөгийн шаардах хуудас нь зөвшөөрсөн захирлын гарын үсэг байхгүй байгаа нь анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллаагүй байна.

### 8.3 Албан шаардлага

Захирлын 2021 оны 02 дугаар сарын 04 өдрийн А/09 дүгээр тушаалаар 2 хүнд 0.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс олгож төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1.Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

## **8.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Зардлын данстай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Байгууллагын албан хэрэгцээний 03-35 УБУ улсын дугаартай авто машины 2017-2020 онд хамаарах 22 удаагийн торгуульд 0.2 сая төгрөг, тайлант 2021 онд хамаарах 0.1 сая төгрөг нийт 0.3 сая төгрөгийг байгууллагаас төлж барагдуулсан байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 "Захирал нь үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах үүрэгтэй" гэж заасантай нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид торгуулийн төлбөрийг буруутай ажилтанаар төлүүлж байх, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

### **2. Хөрөнгийн данстай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Бичиг хэргийн материалаас өмнөх онуудад худалдан авсан 0.7 сая төгрөгийн факсын аппаратын болон каноны хорыг акталж төсвийг үр ашиггүй зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### **3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Тайлант оны 33.3 сая төгрөгийн худалдан авалтад цахим баримт авахгүй байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар заалтын хэрэгжүүлж ажиллах, худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг бүрдүүлж ажиллах.

### **4. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

#### Илрүүлэлт:

Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ажил, нийтлэг үйлчилгээ үзүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулсаны дагуу хоорондын тооцоогоор орж ирсэн 19.6 сая төгрөгийг гүйцэтгэгч Угалз шат ХХК-д шилжүүлсэн ба энэхүү үндсэн үйл ажиллагааны орлогыг борлуулалтын орлого болон зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5 "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал тусгана", 14.4.6 "Нягтлан бодох бүртгэлд бүх зардлыг заавал тусгана" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр заалтын хэрэгжүүлж ажиллах, санхүүгийн тайланд орлого, зардлыг үнэн зөв тусгаж байх.

**5. Татварын өглөгтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Татварын тодорхойлолтоор 0.8 сая төгрөгийн татварын илүү төлөлттэй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал тусгана", 14.4.6-д "Нягтлан бодох бүртгэлд бүх зардлыг заавал тусгана" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Татварын байгууллагатай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, цаашид хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын  
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 7,000.0 мянган төгрөг бичиг хэргийн материалд бүртгэлтэй байна.	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	7,000.0	1	7,000.0								
2	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Бараа материал олгосон шаардах хуудас нь зөвшөөрсөн захирлын гарын үсэг байхгүй байгаа нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй	Санхүүгийн тайланд залруулга хийсэн	1	51,616.8	1	51,616.8								
3	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Захирлын 2021 оны 02 сарын 04 өдрийн А/09 дугаар тушаалын дагуу 2 хүнд бэлэг дурсгалын зүйл олгосон байгаа төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй	Цаашид алдааг давтан гаргахгүй байх	1	300.0					1	300.0				
4	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Бичиг хэргийн материалаас өмнөх онуудад худалдан авсан, ашиглагдахгүй байгаа факсын аппарат, каноны хорыг акталж төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	Төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулж байх	1	663.7								1	663.7	
5	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Тайлант оны 33,315.0 мянган төгрөгийн худалдан авалт нь и-баримтгүй байна.	Худалдан авалтын цахим төлбөрийн бүрдүүлж ажиллах	1	33,315.0								1	33,315.0	
6	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	03-35 УБУ улсын дугаартай автомашины 329.2 мянган төгрөгийн торгуулийг байгууллагаас төлж барагдуулсан байгаа	Цаашид холбогдох ажилтанаар төлүүлж байх	1	329.2								1	329.2	
7	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт ажил, нийтлэг үйлчилгээ үзүүлэх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай гэрээ байгуулсаны	Тайланд орлого, зарлагыг тусгах	1	19,646.9								1	19,646.9	

**Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын  
2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

			дагуу хоорондын тооцоогоор орж ирсэн 19,646.9 мянган төгрөгийг гүйцэтгэсэн "Угалз шат" ХХК-д шилжүүлсэн ба энэхүү үндсэн үйл ажиллагааны орлогыг борлуулалтын орлого болон зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа													
8	Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨҮГ	АХГ-2022/30/НА-СТА-ТӨА	Татварын тодорхойлолтоор 764.2 мянган төгрөгийн татварын илүү төлөлттэй байна.	Татварын байгуулагатай тооцоо нийлж баталгаажуулах	1	764.2									1	764.2
<b>НИЙТ ДҮН</b>					<b>8</b>	<b>113,635.8</b>	<b>2</b>	<b>58,616.8</b>				<b>1</b>	<b>300.0</b>		<b>5</b>	<b>54,719.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 331/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/03/НА-СТА-ТӨААТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8 заасны дагуу Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Захирлын 2021 оны 02 дугаар сарын 04 өдрийн А/09 дүгээр тушаалаар 2 хүнд 300,000.00 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс олгож, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж, зөрчлийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар ТӨААТҮГ-ын захирал Ө.Лувсанренчин, нягтлан бодогч Д.Мөнхтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

  
Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
А.МӨНХЦЭЦЭГ

9006109  
9019120306





